

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

#### Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:**

**Дагаж мөрдөх огноо:**

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:**

2023.12.27

#### Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

#### Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллага

#### Албан тушаалтны нэр:

Нийтийн хэв журам хамгаалах, олон  
нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн  
ахлах байцаагч

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-6

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллагын байр

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын  
гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон  
бусад аюул тохиолдсон, нийтийн эмх  
замбараагүй байдал үүссэн, террорист  
халдлага, онц болон дайны байдал  
зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн  
зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн  
бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГҮҮРЭГ.

#### Албан тушаалын зорилго:

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг  
сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг  
хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, хяналт тавих, алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар  
хангах, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг гүйцэтгэх, зохион байгуулах.

#### Албан тушаалын зорилт:

- Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах.
- Хариуцсан чиг үүргийн хүрээнд алба хаагчдын мэдлэг, ур чадварын түвшин дээшлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавих.
- Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас гаргасан хууль тогтоомж, тушаал шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг танилцуулна;</p> <p>1.2. Хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтан удирдлагаас гаргасан шийдвэр, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр албад, бусад байгууллагатай хамтран зохион байгуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана;</p> <p>1.3. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, бүх нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах, хуулиар харьялануулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, холбогдох дүрэм, журам, заавар, зэвлөмжийг боловсронгуй болгох, тасгийн алба хаагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;</p> <p>1.4. Иргэдийн амгалан тайван байдлыг хангаж, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;</p> <p>1.5. Нутгийн захиргааны төв байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох;</p> <p>1.6. Нэгжийн бүтэц, орон тоо, шаардагдах хүн хүч, техник, тусгай хэрэгслийн судалгаа хийж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>1.7. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, гадаад орнуудын тэргүүн туршлагыг судлах, санал, танилцуулга хүргүүлэх, алба хаагчдад гарын авлага, материал бэлтгэх;</p> <p>1.8. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах үед холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;</p>	<p>Нийтийн хэв журам хамгаалах ажлын үр дүн бодитой үнэлэгдэж, үйл ажиллагаа сайжирна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>

	<p>1.9. Жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;</p> <p>1.10. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын газартай хамтран ажиллах журамд заасны дагуу төр засгийн тэргүүн, гадаадын өндөр хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт, зохицуулалтыг зохион байгуулах;</p> <p>1.11. Эргүүлийн үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, ажлын гүйцэтгэлийг сар, улирал, хагас, бүтэн жилээр авч нэгтгэн дүгнэх, биелэлтийг тооцох, дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, удирдлагад танилцуулах.</p>	Г
	<p>2.1. Гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагын төрөл мэргэжлийн албад, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана;</p> <p>2.2. Хариуцсан чиг үүргийн хүрээнд бүртгэл судалгаа гаргах, хөтлөх, хяналт тавих, танилцуулах;</p> <p>2.3. Гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, бүртгэл судалгаанд үндэслэн нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа ашиглах;</p> <p>2.4. Эргүүлийн хүн хүчиний тооцоонд тодотгол, тулгалт хийх, эргүүлийн чиглэлийн тоог нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг судалж, санал, санаачилга гарган удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;</p> <p>2.5. Эргүүлийн алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, бие бялдар, алба хаагчдын сахилга, ёс зүйг сайжруулах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог хангахад чиглэсэн ажлуудыг зохион байгуулах;</p> <p>2.6. Авто болон явган эргүүлийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал боловсруулж хүргүүлэх, шийдвэрлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>2.7. “Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар”-ын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;</p> <p>2.8. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй</p>	Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>Нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд хууль дүрмийн хэрэгжилт хангагдана.</p>	Г
		Г

	холбогдуулан заавар, зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх, зааварчлах, удирдлагын баримт бичгийг боловсруулах, бүрдүүлэх; 2.9. Эргүүлийн авто машины эд ангийн эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээ, нөхөн хангарт хийлгэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх санал гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, тайлагнах; 2.10. Алба хаагчдыг ажлын байранд нь мэргэшүүлэх чиглэлээр сургалт, дадлага зохион байгуулах, үр дүнг танилцуулах.		Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p><b>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</b></p> <p>1. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2. Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдөж ажиллах</p> <p>4. Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх</p> <p><b>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</b></p> <p>1. Авлыга, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>	<p>Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.</p>	Г Г Г Г


### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	-Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
<b>Мэргэжил</b>	-Эрх зүй /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/;		
<b>Мэргэшил</b>	-Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
<b>Туршлага</b>	Цагдаагийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс офицерын албан тушаалд 2-оос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.		
Үр чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй	
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах	
	Багаар Ажиллах	-Өөрийн мэдлэг үр чадвар, өөрт байгаа мэдлэгийг баг хамт олонтойгоо хуваалцаж хамтран ажиллах. - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.	
	Бусад		

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<p><b>Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:</b> Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга</p>	
<p><b>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</b></p> <p>Батлагдсан орон тоо.</p>	<p><b>Бусад харилцах субъект:</b></p> <p><b>Шууд харилцах:</b> Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан.</p> <p><b>Шууд бус харилцах:</b> Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.</p>

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p><b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b></p> <p>Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА</p> <p></p> <p>T.ГАНЗОРИГ</p> <p>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</p>	<p><b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b></p> <p>Байгууллагын нэр:.....</p> <p>Шийдвэрийн огноо:.....</p> <p>Дугаар:.....</p>
<p><b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b></p> <p>Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР</p> <p>Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр.</p> <p>Дугаар: 1/401</p> <p>ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА</p> <p></p> <p>T.СҮХБОЛД</p> <p>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</p>	
<p><b>Танилцсан:</b></p> <p>Танилцсан албан тушаалтан: .....</p> <p>.....</p> <p>20... оны .... дугаар сарын ....-ны өдөр</p>	

<p>Танилцсан:</p> <p>Танилцсан албан тушаалтан: .....</p> <p>.....</p>
<p>20... оны .... дугаар сарын ....-ны өдөр</p>